



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/383

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 7 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам”-ыг нэгдүгээр, “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлт, үнэлгээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)- д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/315 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



П.АРИУНБУЯН

000003989

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 4 дүгээр сарын 04-ны өдрийн
А/383 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ ЯВУУЛАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба (цаашид "Гамшгаас хамгаалах алба" гэх), мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулахад оршино.

1.2. Аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсэгт бэлэн байдлын үзлэг, шалгалт явуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Үзлэг зохион байгуулах чиглэл

- 2.1. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалт;
- 2.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт;
- 2.3. Гамшгаас хамгаалах төлөвлөлт, түүний хэрэгжилт;
- 2.4. Гамшгийн үед нэмэлт хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө;
- 2.5. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- 2.6. Гамшгаас хамгаалах сургалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил;
- 2.7. Гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалт;
- 2.8. Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал;
- 2.9. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт;
- 2.10. Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт;
- 2.11. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлсэн байдал;
- 2.12. Гамшгаас хамгаалах чиглэлээр гарсан тогтоол, шийдвэр, захирамж, албан даалгавар, Онцгой байдлын байгууллагаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмж, түүний хэрэгжилт.

Гурав. Үзлэг, шалгалтын зохион байгуулалт

- 3.1. Үзлэг, шалгалтыг улсын болон орон нутгийн үзлэг гэж ангилна.
- 3.2. Улсын үзлэг, шалгалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг, орон нутгийн үзлэг шалгалтыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж, үнэлж, дүгнэнэ.
- 3.3. Улсын үзлэг, шалгалтыг нэг жилд 2-3 гамшгаас хамгаалах улсын албанд, 2-3 аймагт тухайн аймгийн нийт сумын 80-аас доошгүй хувийг хамруулан, нийслэлд 4 жилд нэгээс доошгүй удаа тус тус зохион байгуулна.
- 3.4. Улсын үзлэг, шалгалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулдаг гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулийн өмнөх жилд, орон нутгийн үзлэг, шалгалтыг орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас зохион байгуулж байгаа гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуультай хамтатган зохион байгуулна.

3.5. Аймагт жилд 10-аас доошгүй, нийслэлд жилд 30-аас доошгүй хуулийн этгээдэд үзлэг, шалгалтыг зохион байгуулна.

3.6. Улсын үзлэг шалгалтын хуваарийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.7. Улсын үзлэг, шалгалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний, орон нутгийн үзлэг шалгалтын аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулна.

3.8. Гамшгаас хамгаалах улсын албанд үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн даргаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэд дарга, түүнээс дээш албан тушаалтныг, аймаг, нийслэлийн үзлэг, шалгалтыг бүтцийн нэгжийн газрын дарга, түүнээс дээш албан тушаалтныг тус тус томилно.

3.9. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас улсын үзлэг, шалгалт зохион байгуулах талаар албан бичгийг гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлд өмнөх жилийн 4 дүгээр улиралд багтаан хүргүүлж бэлтгэлийг хангуулна.

3.10. Ажлын хэсэг үзлэг, шалгалт зохион байгуулсан үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

Дөрөв. Эрх, үүрэг

4.1. Үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн эрх, үүрэг:

4.1.1. үзлэг, шалгалт зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж батлуулах, хэрэгжилтийг хангах;

4.1.2. энэ журмын 2 дахь хэсэгт заасан чиглэлийн хүрээнд үзлэг шалгалтыг зохион байгуулах;

4.1.3. гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичигтэй танилцах, шаардлагатай нэмэлт мэдээлэл гаргуулах;

4.1.4. гамшиг, ослын цагийн байдал өгч штабын болон тактикийн дадлага зохион байгуулж бэлэн байдлыг шалгах;

4.1.5. үзлэгийн бэлтгэлийг хангахтай холбоотой мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгөх;

4.1.6. төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууц хадгалалт хамгаалалтыг сахих;

4.1.7. үзлэгийн үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өгөх;

4.1.8. үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шийдвэр хүргүүлэх;

4.2. Үзлэг, шалгалтад хамрагдах аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсгийн эрх, үүрэг:

4.2.1. үзлэг, шалгалтад хамрагдахтай холбоотой Онцгой байдлын байгууллагаас заавар, зөвлөмж, сургалт авах;

4.2.2. үзлэгт, шалгалтад бэлтгэж, бэлэн байдлыг хангаж бүрэн хамрагдах;

4.2.3. үзлэг, шалгалт зохион байгуулахад шаардагдах зардлыг гаргах;

4.2.4. ажлын хэсгийг үзлэг, шалгалт зохион байгуулах нөхцөл боломжоор хангах;

4.2.5. үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг заагдсан хугацаанд арилгах, энэ талаар илтгэх хуудсаар ажлын хэсэгт ирүүлэх.

4.3. Ажлын хэсгийн ахлагчийн эрх, үүрэг:

4.3.1. үзлэг, шалгалтыг удирдлага зохицуулалтаар хангах;

4.3.2. ажлын хэсгийн гишүүдийн үйл ажиллагаа, сахилга, зохион байгуулалтад хяналт тавих;

4.3.3. ажлын хэсгийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах;

4.3.4. бэлтгэл ажлын төлөвлөгөө, үзлэг шалгалтын үнэлгээ, тайлан мэдээг хянаж, баталгаажуулах;

4.3.5. үзлэг, шалгалт зохион байгуулахдаа хувийн ашиг сонирхлоос ангид байж, төрийн албан хаагчийн ёс зүйг сахин ажиллах.

4.4. Ажлын хэсгийн гишүүдийн эрх, үүрэг:

4.4.1. үзлэг, шалгалттай холбоотой ажлын хэсгийн ахлагчид санал, хүсэлт гаргах;

4.4.2. үзлэг, шалгалтыг удирдамжийн дагуу зохион байгуулж, үнэн зөв үнэлэх;

4.4.3. үзлэг, шалгалт зохион байгуулах бэлтгэлийг хангах;

4.4.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хувийн сахилга, зохион байгуулалтыг чанд сахиж, байгууллагын болон албаны нууцыг хамгаалах;

4.4.5. үзлэг, шалгалт зохион байгуулахдаа хувийн ашиг сонирхлоос ангид байж, төрийн албан хаагчийн ёс зүйг сахин ажиллах

4.4.6. үзлэг, шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэж ажлын хэсгийн ахлагчид танилцуулж, баталгаажуулна.

Тав. Бусад

5.1. Үзлэгийг зохион байгуулахад шаардагдах зардлыг үзлэгт хамрагдагч тал тухайн жилийн төсөвт тусгаж, хариуцна.

5.2. Ажлын хэсэг үзлэг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үзлэгийн тайланг нэгтгэж баталгаажуулан удирдамж баталсан албан тушаалтанд танилцуулна.

5.3. Бэлэн байдлын үзлэгийн дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг гамшгаас хамгаалах улсын алба, хуулийн этгээдийн удирдлага, үзлэг, шалгалтад хамрагдсан аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.4. Бэлэн байдлын үзлэг, шалгалтын дүнг тухайн жилийн эцэст төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагыг дүгнэх ерөнхий үзүүлэлтэд, аймаг, нийслэлээс зохион байгуулсан үзлэг, шалгалтад үзүүлсэн дүнг тухайн сум, дүүргийн жилийн эцсийн ажил дүгнэх ерөнхий үзүүлэлтэд тус тус оруулж дүгнэнэ.

Зургаа. Үнэлгээ

6.1. Бэлэн байдлын үзлэгийг дүгнэхдээ “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлт”-ийн хүснэгтэд заагдсан нарийвчилсан үзүүлэлт тус бүрээр 0-100 хүртэл хувиар дараах шалгуураар үнэлж нийт онооны нийлбэрийн дунджийг гаргана. Үүнд:

6.1.1. Зорилт, арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, бүрэн хэрэгжиж тавьсан зорилгодоо хүрч сайн үр дүнд хүрсэн бол “Маш сайн” буюу 90-100 оноо;

6.1.2. Зорилт, арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн, төлөвлөгдсөн ажлууд хийгдэж гол үр дүн гарч эхэлж байгаа бол “Сайн” буюу 80-89 оноо;

6.1.3. Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх холбогдох байгууллагын шийдвэр гарсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, үйл ажиллагаа эхлээд тодорхой үр дүн гарсан, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол “Хангалттай” буюу 70-79 оноо;

6.1.4. Зорилт, арга хэмжээг тодорхойлсон хэдий ч илүү сайн тодорхойлох шаардлагатай, хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа хийгдэж

боловсруулалтын шатандаа яваа, төсөв санхүүг үр дүнтэй зарцуулаагүй “Дутагдалтай” буюу 50-69 оноо;

6.1.5. Зорилт, арга хэмжээг оновчгүй тодорхойлсон, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв санхүүг шийдвэрлээгүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй, зорилтыг хэрэгжүүлэх ямар нэгэн ажил зохион байгуулагдаагүй бол “Хангалтгүй” буюу 0-50 хүртэл оноо өгч тус тус үнэлнэ.

6.2. Аймаг, нийслэлийн нэгдсэн дүнг гаргахдаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дүнг нэгтгэж дундажлан гаргана.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2023 оны 8 дүгээр сарын 20-ны өдрийн
 А/383 дугаар тушаалын хоёрдугаар хэсэрт



ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Ерөнхий үзүүлэлт	Нарийвчилсан үзүүлэлт
1	Удирдлага зохион байгуулалт	а Удирдлагын шуурхай бүлэг, штабыг томилгоожуулж удирдлага зохицуулалт, чиг үүргийг оновчтой тогтоосон байдал, удирдлагын шийдвэр гаргалт
		б Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг томилгоожуулж, удирдлага зохицуулалт, чиг үүргийг оновчтой тогтоосон, гамшиг ослын хариу арга хэмжээний дадлага, чадвар эзэмшсэн байдал
		в Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан (орон тооны болон орон тооны бус)-ыг томилон ажиллуулсан, тухайн албан тушаалтны гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлсэн байдал
		г Байнгын болон нөөц, удирдлагын байрыг томилгоожуулж, тоногдсон байдал, (тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, байр зүйн болон план зураг)
		д Хээрийн хөдөлгөөнт удирдлагын байр, түүний хээрийн бэлтгэл (хүнс, усны хангалт, шатахууны нөөцийн байдал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, байр зүйн болон план зураг)
		е Орон нутгийн бэлэн байдлын үзлэг, шалгалт зохион байгуулсан байдал, үр дүн
2	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах ажил, түүний биелэлт	а Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийгдсэн эсэх
		б Эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөсөн байдал, түүний хэрэгжилт
		в Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт
3	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, төлөвлөлт, түүний хэрэгжилт	а Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүний боловсруулалт, тодотгол хийсэн байдал, хэрэгжилт
		б Цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодис, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг бол тухайн ослоос хамгаалах төлөвлөгөө, тодотгол хийсэн байдал, хэрэгжилт
4	Гамшгийн үед нэмэлт хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө	а Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед нэмэлт хүн, хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө
		б Дайчлан гаргах хүн хүч, багаж, техник, материал хэрэгслийн бэлэн байдал, бүртгэл, тооцоо, судалгаа, гэрээ, санамж бичиг байгуулсан, тодотгол хийдэг эсэх, бэлэн байдал
5	Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	а Хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах түр орон байрыг томилгоожуулан, нэн шаардлагатай хэрэгцээт зүйлсийг бэлтгэж, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн байдал
		б Түр цугларах аюулгүйн талбайг баталгаажуулж, тэмдэгжүүлсэн байдал
		в Нисдэг тэрэг нисэх, буух газрыг тодорхойлж, төхөөрөмжилсөн эсэх

6	Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа	а	Удирдах албан тушаалтны сургалт
		б	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт
		в	Сайн дурын хэсгийн сургалт
		г	Хуулийн этгээдийн ажилтны сургалт
		д	Иргэдийн сургалт
		е	Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгаа, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэсэн байдал
7	Гамшиг, ослоос хамгаалах аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгслийн хангалт	а	Томилгоот бүрэлдэхүүний гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, нөхөн хангалт, ашиглалт, хадгалалтын байдал
		б	Хүн нэг бүрийн хээрийн үүргэвч, хамгаалах хэрэгслийн хангалт, түүний чанар байдал, ашиглалт, хадгалалт сайн эсэх
8	Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал	а	Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал
		б	Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах арга, ажиллагаанд алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсэг, хүн амыг сургаж дадлагажуулдаг эсэх
		в	Гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг хүн амд хүргэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байдал
9	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	а	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, зарцуулсан байдал
		б	Хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулсан байдал
10	Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт	а	Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлт, зарцуулалт, тооцоо судалгаа, хадгалалт хамгаалалт (мөнгөн хөрөнгө, багаж, техник, хэрэгсэл, бараа материал, шатах тослох материал, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт)
11	Хөгжлийн бодлого төлөвлөлтөд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлсэн байдал	а	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, үндсэн чиглэлд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгасан байдал, хэрэгжилт, үр дүн
		б	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээ, хэрэгжилт, үр дүн
12	Гамшгаас хамгаалах чиглэлээр гарсан тогтоол, шийдвэр, захирамж, албан даалгавар, үүрэг, чиглэл, зөвлөмж, түүний хэрэгжилт	а	Гамшгаас хамгаалах чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
		б	Гамшгаас хамгаалах чиглэлээр харьяалах дээд болон тухайн шатны Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт
		в	Онцгой байдлын байгууллагаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмж, албан шаардлага, түүнийг хэрэгжүүлсэн байдал

Аймаг, нийслэлийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, д, е, 2 а, в, 3 а, 4, 5, 6а, б, в, д, е, 8, 9 а, 10, 11, 12 а, в дүгээр заалтын дагуу;

Сум, дүүргийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1 а, б, в (в онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй суманд), г, д, 2 а, б, в (в суманд хамаарахгүй), 3 а, 4, 5, 6 а, б, в, д, е, 7, 8, 9 а, 10, 11 а, б, 12 дугаар заалтын дагуу;

Гамшгаас хамгаалах албаны бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1 а, б, в (в гамшгаас хамгаалах орон нутгийн албанд хамаарахгүй), г, д, 2 а, б, 3 а, 4, 5 а, б, 6, 7, 8, 9 а, 10, 12 дугаар заалтын дагуу;

Хуулийн этгээдийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, 2 а, б, 3, 5 а, б, в, 6 г, 7, 8 а, б, 9 б, 10, 12 дугаар заалтын дагуу;

Сайн дурын хэсэгт бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 3 а, 6 в, 7, 8 а, б, 12 дугаар заалтын дагуу тус тус үнэлнэ.

---oOo---